



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 4/438

Номгон

Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг  
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.1а заалт, Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалын хавсралт “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг зарцуулахыг төсөв захирагч нарт зөвшөөрсүгэй.

2.Төсөвт байгууллагууд өөрийн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалын хавсралт “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам”-ын дагуу зарцуулахыг төсөвт байгууллагуудын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210015